



“БАЯН СУВАРГА АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө, 64, ЭДО хаус, 405 тоот
Утас: 976-70159158

2021.03.25 № 06.

танай _____-ны № _____ - т

**“ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВ” ТББ-ЫН
УДИРДЛАГАД**

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Бид танай байгууллагын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Зөрчилгүй дүгнэлт

Танай байгууллага 2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн “Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага” хэсэгт харуулсан болно. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагын дагуу танай байгууллагаас хараат бусаар ажиллах үүргээ бүрэн биелүүлж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй зүйлсийг аудитын гол асуудлууд гэж үзнэ. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хамраагүй тул түүнд баталгаажуулалт гаргахгүй.

Удирдлага ба засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь байгууллагын хүлээх үүрэг юм. Энэхүү үүрэгт залилан,

алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулах үүрэг бүхий дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх ажлууд багтана. Удирдлага санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг цаашид тасралтгүй явуулах үүрэг хариуцлага хүлээсэн байна.

Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудын талаар хараат дүгнэлт өгөх нь бидний үүрэг хариуцлага юм.

Бид танай байгууллагын санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, түүнийг Аудитын олон улсын стандартыг баримтлан хийв. Аудит хийхдээ аудитын горим (шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, тасалбар болголт, тулгалт гэх мэт)-уудыг ашигласан.

Байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан бөгөөд цаашид ч уг зарчмыг баримтлах юм байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн хураангуйг хавсаргав.


ЗАХИРАЛ _____ /С.ДОЛЖИНСҮРЭН/
"БАЯН СУВАРГА АУДИТ" ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2022 ОНЫ 03 ДУГААР
САРЫН 25-НЫ ӨДӨР